АЗИ, БАРУУН НОМХОН ДАЛАЙН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ (IFAWPCA)-ИЙН 45 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГАНД МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД ОРОЛЦОХООР МОРДЛОО



IFAWPCA-ийн 45 дахь дахь удаагийн Чуулган”-ыг Мальдив Улсын Мале хотноо 2022.11.14-19-ний хооронд Мальдивын Барилгын үндэсний аж үйлдвэрийн ассоциаци нь 2007 онд IFAWPCA-д элссэнээсээ хойш анх удаа өөрийн эх оронд зохион байгуулагдах гэж байна. Тус арга хэмжээнд IFAWPCA-ийн 19 гишүүн орнуудын Ассоциациудын удирдлагууд, гишүүн байгууллагууд, салбарын зочид төлөөлөгчид оролцох гэж байна. Тус Чуулган нь нь 2020 онд зохион байгуулагдах байсан боловч цар тахлын улмаас хойшлогдсоор энэ жил зохиогдохоор боллоо. IFAWPCA-ийн Чуулганыг 2 жилдээ нэг удаа гишүүн орнуудын Ассоциациудын цагаан толгойн үсгийн дарааллын дагуу ээлжлэн зохион байгуулдаг билээ.

IFAWPCA нь 19 гишүүн орнуудын Ассоциациудыг эгнээндээ нэгтгэсэн бөгөөд МБҮА ТББ нь 2015 онд гишүүнээр элсэж, улмаар 2018 оноос тус нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүнээр нь сонгогдон ажиллаж байна.

Энэ удаагийн IFAWPCA-ийн 45 дахь дахь удаагийн Чуулганы арга хэмжээнд МБҮА ТББ-ыг төлөөлж Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Л.Хулан, Гишүүн, “Урьхан санаа” ХХК-ийн Захирал Б.Чадраабал нар оролцож байна.

Чуулганы үеэр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь Монгол Улсын Барилгын салбарын нөхцөл байдал, Хөшгийн хөндийд хэрэгжих гэж буй шинэ төслийн талаар товч илтгэлийг тавих болон IFAWPCA-ийн Удирдах зөвлөлийн гишүүний сонгуульт ажил үүргийг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулангаас шилжүүлэн авч, Тангараг өргөх ёслолын арга хэмжээнд оролцсоноор албан ёсны “Батламж”-ыг хүлээн авах болно.

Түүнчлэн, МБҮА ТББ-ын төлөөлөгчид нь IFAWPCA-ийн Ерөнхийлөгч Мохамед Али Жанах-тай МБҮА ТББ-ыг Олон улсын Зөвлөх инженерүүдийн холбоо (ФИДИК)-нд бусад IFAWPCA-ийн гишүүн орнуудын Ассоциациудыг элсүүлэхэд нь үзүүлдэг туслалцаа дэмжлэгийг авах асуудлаар яриагаа үргэлжлүүлэхээс гадна IFAWPCA-ийн бусад 18 гишүүн орнуудын Ассоциациудын Ерөнхийлөгч болон удирдлагуудтай Монгол Улсад татан оруулж хэрэгжүүлж болох хөрөнгө оруулалт, ажиллах хүч, төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа болон бусад холбогдох асуудлаар санал солилцож уулзах, мөн дараа удаагийн ээлжит IFAWPCA-ийн Чуулганыг Монгол Улсад ээлжийн дагуу зохион байгуулах эсэх талаар Чуулганаар

хэлэлцүүлэх, Чуулган болон Чуулганы Хороонуудын уулзалтуудад оролцож мэдээ мэдээллээ хуваалцах үйл ажиллагаанд оролцох болно.



Энэ удаагийн Чуулганыг байгаль орчныг хамгаалах, улс орныхоо өв соёлыг хадгалах, ЮНЕСКО-оос зарласан дэлхийн дархан цаазат газруудыг дэмжих нь чухал гэдгийг харуулах зорилгоор “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАА ХАМГААЛЖ, ИЛҮҮ САЙХАН ЕРТӨНЦИЙГ БҮТЭЭЦГЭЭЕ” уриа доор явуулахаар болсон.

АЗИ, БАРУУН НОМХОН ДАЛАЙН ГЭРЭЭЛЭГЧДИЙН АССОЦИАЦИУДЫН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ ЮУ ХИЙДЭГ БАЙГУУЛЛАГА ВЭ?

Дэлхийн II дайны дараа барилгын салбар болоод хотын байгууламжийг дахин сэргээх зорилгоор 8 орны барилгын төлөөлөгчид (Австрали, Хятад (Тайван), Индонез, Япон, Солонгос, Пакистан, Филиппин, Сингапур) нь 1956 онд Филиппин Улсын Манила хотод IFAWPCA буюу Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэгийг үүсгэн байгуулжээ. Өнөөдөр тус байгууллага нь Зүүн Өмнөд Ази болон Өмнөд Азийн нийт 19 орны барилгачдын ахан дүүсийг нэгтгэж, олон улсын нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, бүс нутгийн Засгийн газар болон Барилгын гэрээт гүйцэтгэгчдийн хооронд ашигтай харилцааг хөгжүүлэн, иргэний болон барилгын төслүүдийг хэрэгжүүлэн дэмжин ажиллаж байна.

ЗОРИЛГО БА ЗОРИЛТ:

1. Ази, баруун номхон далайн газарзүйн бүс нутгийн гэрээлэгч байгууллагуудын хооронд илүү нягт харилцаа, холбоог бий болгохоос гадна, олон улсын хамтын ажиллагааг бий болгох
2. Барилгын технологийн мэдээллийг солилцох
3. Асуудалд харилцан ашигтай, шийдлийг олох зорилгоор Засгийн газар болон Гэрээлэгчдийн харилцааг хөгжүүлэх
4. Тухайн гишүүн орнуудын хууль тогтоомжийн дагуу барилга байгууламжийг барих төслийг хэрэгжүүлэх зэрэг байна.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ:

1. Үндсэн хууль, дүрэм, Чөлөөт аж ахуйн нэгжийн тухай тунхаглал, Олон улсын үйл ажиллагааны дүрэм болон IFAWPCA-ийн зорилгод нийцүүлэн ажиллах
2. Арбитрчаар ажиллахдаа барилгын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шударга ажиллах
3. Гутаан доромжилсон мэдээллийг өгөх, тендерийн үнийг хасах саналыг гаргахгүй байх

4. Нууц үнийн саналыг ашиглан илүү ихийг санал болгох эсвэл хямд гэрээ хэлэлцээрийг хийх замаар ажилчид болон техникийн ажилтнуудад үндэслэлгүйгээр нөлөөлөхөөс зайлсхийх
5. Барилгын зөвлөхийн үүргийг гүйцэтгэхдээ тохиролцсон төлбөрөөс өөр хураамжийг авахгүй байх
6. Хууль бусаар нөлөөлөх, аливаа саналыг хүлээж авахгүй байх, арбитрчаар ажиллахдаа барилгын гэрээ, хууль тогтоомж, ёс заншил зэрэгт нийцүүлэн шударга ажиллах
7. Хамтран ажиллагсдын нэр хүнд болон бизнест шууд болон шууд бусаар хохирол учруулахгүй байх
8. Бусад барилгын салбарын холбоод болон бусад байгууллагуудыг хүлээн зөвшөөрч, хамтран ажиллах
9. Хүн төрөлхтний хөгжил дэвшлийн төлөө нийгэм, барилгын салбарын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага болох барилгын технологийн туршлагыг солилцох, сургах, судалгаанд хувь нэмрээ оруулах зэрэг байна.

Дараах НҮБ-ын зорилтын доор үйл ажиллагаа явуулдаг

- ЗОРИЛГО 8: Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох
- ЗОРИЛГО 12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих

ДОТООД БҮТЭЦ:



IFAWPCA-н 45 дахь Ерөнхийлөгч

Мохамед Али Жанах

Мохамед Али Жанах нь Мальдив Улс болон хилийн чанадад 300 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг Хотелс энд ресорт констракшн ХХК-ийн ТУЗ-ийн Дарга юм. Тэрээр төслийн үзэл баримтлал, зураг төсөл, гэрээний баримт бичиг, хэрэгжилт, чанарын удирдлага, хөгжил, хангамж, логистикийн чиглэлээр гүйцэтгэх удирдлагын түвшинд 30 жил ажилласан туршлагатай. Ноён Жанах нь АНУ, Их британи, Итали, Нидерланд, Австрали, Шинэ Зеланд, Сингапур, Малайз, Хятад, Хонг Конг, Япон, Тайланд, Энэтхэг, Индонез, Саудын араб, Катар, Бахрейн, Арабын Нэгдсэн Эмират, Турк зэрэг орнуудаар аялангаа барилгын салбарын үндсэн зарчмуудыг судалж, дэлхийн алдартай хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоожээ. Мөн түүнчлэн, тэрээр үл хөдлөх хөрөнгийн бизнесийг эрхэлдэг бөгөөд зочид буудал, амралтын газар зэрэг үл хөдлөх хөрөнгийг худалдан авч зардаг байна. Ноён Жанах нь 2001 оноос хойш Мальдивын хоёр дахь том салбарын жишиг тогтоогч болох Мальдивын Барилгын үндэсний аж үйлдвэрийн холбоо (MACI)-ны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.



IFAWPCA-н 1-р Дэд ерөнхийлөгч

Рамеш Шарма

Ноён Рамеш Шарма нь Трибхуваны их сургуулийг төрийн удирдлага, Филиппиний Адамсоны их сургуульд бизнесийн удирддагаар магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр Балбын Барилгын гүйцэтгэгчдийн ассоциаци (FCAN)-ийн байнгын гишүүн бөгөөд 1998-1999 онд тус холбооны Ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. Тэрээр одоо FCAN-ийн Гүйцэтгэх хорооны зөвлөхөөр ажиллахаас гадна Балбын Худалдааны танхим болон Трипурешора Ротари клубийн байнгын гишүүдийн нэг юм. Одоогоор ноён Шарма нь 1966 онд үүсгэн байгуулагдсан “Шарма энд компани”- ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тус компани нь “А” зэрэглэлийн барилгын компани бөгөөд үйлдвэр, банк, эмнэлэг, ус дамжуулах шугам хоолой, усан сан, зам, гүүр, явган хүний зам, ус зайлуулах болон био инженерийн ажил, мөн ногоон байгууламж, цахилгаан дэд станц зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.



IFAWPCA-н Ерөнхий нарийн бичгийн дарга

Ахмед Алау Али

Ноён Алау Али нь АНУ-ын баруун Мичиганы их сургуулийг Бизнесийн удирдлагаар бакалаврын зэрэг хамгаалсан.Тэрээр Алиа Группийн салбар компаниуд болох Алиа инвестмент ХХК болон Алиа Констракшны ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг.Алиа Констракшн ХХК нь барилгын салбарынхаа анхдагч тэргүүлэгчдийн нэг бөгөөд төрөл бүрийн дэлхийн хэмжээний төслүүдийг гүйцэтгэдэг. Нэр хүндтэй төслүүдийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 1980 онд Ерөнхийлөгчийн нэрэмжит “Барилгын салбарын тэргүүн”-ий шагналаар шагнуулжээ. Алиа Констракшн ХХК нь ISO болон OHSAS гэрчилгээтэй орон нутгийн цорын ганц барилгын компани бөгөөд 2014 онд ISO 9001:2008, 2017 онд OHSAS 18001:2007 зэрэг стандартуудад хүрсэн байна. Ноён Али бол Мальдивын Үндэсний барилгын аж үйлдвэрийн ассоциацийн (MACI) Дэд ерөнхийлөгч бөгөөд Үүсгэн байгуулагч гишүүдийн нэг юм. Одоогоор тэрээр Мальдивын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн Даргаар давхар ажиллаж байна.



IFAWPCA-н Гүйцэтгэх захирал

Леви В. Эспириту

Леви В.Эспириту нь “Датем инкорпорэйтэд” компанийн Үүсгэн байгуулагч гишүүнээс гадна одоогийн Гүйцэтгэх захирал юм. Тэрээр 2010-2011 онд Филиппиний Барилгачдын Ассоциацийн (PCA) Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан бөгөөд одоогийн байдлаар IFAWPCA-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Датем инк компани нь 1984 онд өндөр ур чадвартай барилгын мэргэжилтнүүдээс бүрдэн анх байгуулагджээ. Ноён Леви болон түүний баг нь 90-ээд онд барилгын угсармал системийг Филиппиний барилгын салбарт анх нэвтрүүлжээ.



IFAWPCA-н Илтгэгч

Дэсмонд Л.Хилл

Ноён Десмонд Хилл нь Пента-оушен констракшн компанийн ерөнхий менежерээр болон Олон улсын барилгын инженерийн, барилга угсралтын группийн Гэрээт удирдлагын хэлтсийн Даргаар нэгэн зэрэг ажилладаг. Тэрээр 35 гаруй жил барилгын томоохон төслүүд дээр ажилласан туршлагатай. Ноён Дэсмонд нь Сингапурын үндэсний их сургуулийг Барилгын инженерээр төгссөн. Тэрээр Сингапурын инженерүүдийн хүрээлэнгийн Гишүүн, Сингапурын Төслийн менежерүүдийн нийгэмлэгийн Гишүүн, Сингапурын Төлбөрийн хэрэгжилтийн хуулийн итгэмжлэгдсэн Арбитрчаар ажилладаг.